



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/144

Хэрлэн сум

Гэр зуслангийн гадна цахилгаан хангамжийн угсралтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжих Хэрлэн суманд Гэр зуслангийн гадна цахилгаан хангамжийн угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Ж.Гантулга	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Н.Үнэнбат	Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Б.Сандагдорж	Багануур зүүн өмнөд бүс цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Хэнтий аймаг дахь салбарын инженер
	Д.Оюун	Төрийн бус байгууллагын төлөөлөл
	Х.Гонгор	Иргэний төлөөлөл

2.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ